

## ОЙРАД ХУВЦАСНЫ ОНЦЛОГ БА НЭР ТОМЪЁОНЫ ХАРЬЦУУЛАЛТ

**Б.БАДМА-ОЮУ**

*ШУА-ийн Түүхийн хүрээлэн*

XX зууны эхэн үе хүртэл ойрад монголчуудын дээл хувцас, малгай гутлын хийц маяг, тэдгээрийг нэрлэж заншсан байдал нь Төв Монголчуудаас нэлээд ялгаатай байжээ. Өөрөөр хэлбэл ойрад хувцсанд монгол хувцасны түүхийн нэлээд түрүү үеийн онцлогийг зарим талаар хадгалж ирсэн болов уу гэлтэй байдаг. Ойрад монголчуудын өмсөж эдэлж явсан хувцасны нийтлэг болоод зарим онцлог шинжүүдээс өгүүлбэл:

**Малгай.** Ойрадууд малгайг махлай хэмээнэ. Халх болон зүүн монголчуудын малгай шовгор гозгор оройтой байхад ойрадуудын малгай намхан навтгар оройтой байдаг. Малгайн төрөл зүйл арвин бөгөөд дөрвөдийн төгрөг, дуулха, хавлан, тойруул, баядын товь, өөлдийн тумлай, торгуудын туувь, халван, мянгадын сээтгэр малгай гэх зэрэг нутаг нутгийн онцлог хэв шинжийг хадгалсан малгай байжээ. Өөлдүүд орой дээрээ сампинтай, хөх бүч, хөх оройтой, хойшоо илүү гарсан залаа бүхий тумлай малгайгаараа бусад зэргэлдээх ястнуудаас ялгарна. Тумлай малгайг яагаад хөх бүчтэй болсон тухай нутгийн настайчууд, өөлдийн ард түмэн Манжийн түрэмгийлэгчдийн эсрэг гавъяатай тэмцсэн тул Галдан бошигтоос шагнасан хэмээн домоглодог байжээ<sup>22</sup>.

Харин урианхай нар малгайн дээрээ улаан залаа хаддаг нь монгол овогтны тэмдэг хэмээн бэлэгдэн хадсан түүхтэй. Мөн урианхай нарын малгайг бадам цэцгийг дуурайлган хийсэн хэмээн домоглож, Баруун Алтай нутагтай

Барын арьсан хэвнэгтэй

Барлаг боол зарцтай

Бадам цэцэг малгайтай урианхай нар хэмээн дуулж явсан гэдэг<sup>23</sup>. Баядын туувь малгай орой дээрээ сампинтай, урт залаатай, харин дөрвөдийнх богино, цацаг нь ар тийш эсвэл 4 зүг намирч байх онцлогтой байна.

Баядууд сээтгэр, тойруул тоорцог, царцаа хар, туувь, товь, дуулха гэх мэт малгайнуудыг хэрэглэж байжээ. Баяд малгай нь бусад ястны малгайнуудаас ялгарах учир дөрвөдүүд тэднийг “хар хэрмэн нутагтай, хар хүрээтэй малгайтай хар баяд” гэж хошигнон нэрлэдэг байжээ. Мөн зуны цагт торгууд, мянгад нар цагаан дөрвөлжин алчуураар толгойгоо тойруулан ороодог. Иймээс ч “цагаан алчууртай л байна, мянгад байлгүй, улаан алчууртай л байна, мончоого байлгүй” гэсэн хочилсон үг гарсан ажээ<sup>24</sup>.

**Дээл.** XIX-XX зууны үеийн ойрадуудын эдэлж хэрэглэж байсан хувцас хунарыг дотор нь ангийн дээл, хирвээстэй дээл, уужтай дээл гэж гурав ангилж болно. Анчин хүний өмсдөг ангийн тоодгор дээл бол нэлээд эртний уламжлалтай юм. Анчин хүний дээл нь гүйж харайх, гэтэх нуугдахад нэн тохиромжтой хөнгөн оготор байна. Ангийн тоодгор дээлийг эрт үед ан гөрөөгөөр амьдардаг байсан ойн иргэд овог аймгуудын өмсөж эдэлж байсны уламжлал байж болох юм. Учир нь тэр үеийн амьдралын гол үүсвэр нь ан гөрөө байсан тул ангийн арьс ширээр хувцас, гутал зэргийг хийж хэрэглэж байсан байна. Хирвээстэй дээл бол ойрадын бүх ястан угсаатанд тархсан дээл юм. Энэ нь эргэн тойрон нарийн эмжээртэй, түүний дотуур бараан өнгийн эдээр хийсэн өргөн хирвээстэй байдгаараа онцлог. Дээр үед дээлийн хирвээсийг хар,

<sup>22</sup> Г.Батнасан. “Монгол ардын хувцас” УБ. 1989

<sup>23</sup> Арван гурван хүлгийн дуун. Эмхтгэсэн Ж.Цолоо УБ 1987

<sup>24</sup> Г.Батнасан. “Монгол ардын хувцас” УБ. 1989, тал 400

цагаан хурганы арьс, ангийн үс зэргээр хийдэг байсан бол XIX зууны сүүлч үеэс хар хамба хилэн, харааг хоргойгоор голдуу хийх болжээ<sup>25</sup>.

Захчины эмэгтэй дээлийн ханцуйг нэлээд өргөн хийдэг байв. Үүнийг үр хүүхдээ ханцуйдаа нууж дайснаас амийг нь аврах боломжтой хэмээн ийнхүү хийдэг байжээ. Энэ заншил бүр сүүл үе хүртэл байлаа. Баяд эхнэр дээлийн захыг цагаан бөсөөр хийнэ. Үүнийгээ Алтай таван богдын ноён оргилыг дүрсэлсэн гэх, мөн цагаан өнгийн бөсөн алчуурт хүүхдээ өлгийдөн дайнд авч явсан, тэрчлэн эхийн цагаан сүү болон сүү цагаан идээг бэлэгдэн хийсэн гэсэн аман домог яриагаар тэмдэглэдэг<sup>26</sup>.

Мянгад залуучуудын дээлийн зах нь босоо (эргэдэг) гадна талаар нь бор, хар, цагаан хурганы арьсаар өнгөлсөн байдаг. Баяд авгайн тэрлэгний нударганы омог хурц, тэрлэгний ханцуйн уг ухаараа баяд авгайнх өргөн тавиу байхад дөрвөд авгайнх баядынхаас бага бариувтар байх жишээтэй.

Ойрад монголчууд нийт Монголчуудын адил өвөл нэхий, хурганы арьс, ангийн үсэн дэвэл (дээл) үч зэргийн өмсч дулааны улиралд лавшиг буюу тэрлэг, нөхөрт гарсан эмэгтэйчүүд тэрлэгний гадуур ханцуйгүй цэгдэг өмсдөг байв. Цэгдэг нь халх уужтай харьцуулахад цэгдэгний ар өвөр талын суга ялангуяа ар хоёр суганы малтаар их бөгөөд мөр нь том далбагар ажээ.

Оросын судлаач Г.Н.Потанин Баруун монголын эмэгтэйчүүдийн дээл мөрөн дээрээр түнтгэргүй, тэрлэг цэгдэг нь ихээхэн урт байсан тухай тэмдэглэсэн байдаг<sup>27</sup>.

Өөлд эмэгтэйчүүдийн цэгдэг 2 янз байв. Үүний нэг нь даалимба, сатин, жигүүнээр хийсэн богино цэгдэг юм. Энэ нь ардаа оноотой атлаа урд хормой нь ташуу хийгдсэн байна. Настангуудын хэлж байгаагаар богино цэгдэгийн хормой хэрхэн богино болсон тухай гүүний хөх дуурайлган хийсэн гэх буюу бас хойтын Амарсанаа тэмдэг болгож ташуу болгосон гэсэн домгууд өгүүлдгээс үзвэл нэлээд эртний байдлаа хадгалсан болох нь тодорхой. Харин золгууд хийх, гал тахих, дээр мөргөх, нүүдэл хийх үед гоёлын зориулалтаар урт цэгдэгийг өмсдөг байжээ<sup>28</sup>.

**Гутал.** Дөрвөдөд харчин гос, канчин гос, дөрвөд гос, монгол гос гэсэн 4 янзын гутал хэрэглэж байсан бөгөөд тэдний аль ч улиралд нийтлэг өмсөж байсан гутал нь дөрвөд госон юм. Дөрвөд госон (гутал) бол нийт ойрад монголчуудын улмаар монгол гутлын нэлээд эртний хэлбэр төрхийг хадгалж үлдсэн гутал гэж хэлж болно. Дөрвөд госонг гурван давхар ширэн ултай харин баяд госонг ширмэл эсгий ултай хийх тус тусын ялгаатай. Алтайн урианхайн эрчүүдийн голлон өмсдөг гутал бол маага госон байв. Түүний нэг онцлог бол тусгайд нь хийсэн оймсгүй, гутлын дотор талд нь хэлбэр хэмжээнийх нь дагуу зузаан эсгий барьж оёод оймс орлуулж хийдэг<sup>29</sup>.

Баядууд сайр госон, годон госон, улаан госон гэх зэрэг ажил хөдөлмөрийн онцлогт тохирсон гутлуудыг хийж өмсдөг байв.

Торгуудууд хонины ахар ноосоор битүү тохойлдож хийсэн уландаа бод малын арьсаар таваг хийж бүрсэн тоокуу хэмээх оймсон гутал хийж өмсдөг. Тоокуу гутлыг ойрадын бусад ястнууд огт хэрэглэдэггүй. Харин Алтайн урианхайчуудын өвлийн улиралд өмсдөг эрэгтэй хүний өдөр тутмын "тооку хос" нь торгуудын тоокуутай ерөнхийдөө ижил. Энэ гар хийцийн өвөрмөц гутлын тухай,

Тоокуу нэгэн гос тов хийгээд байна

Торгууд нэгэн сэвгэр намайг гээд байна

Мянган харлагтай хонийг мянгадын давд хариулна

<sup>25</sup> С.Бадамхатан. "Хөвсгөлийн дархад ястан" УБ.1965, тал 144

<sup>26</sup> Х.Нямбуу, Арьяасүрэн "Монгол ёс заншлын их тайлбар толь" 1992 УБ, тал 222

<sup>27</sup> Г.Н.Потанин. "Очерки северо-западной Монголии" СПб 1981.ВП, тал 154

<sup>28</sup> Г.Батнасан. "Монгол ардын хувцас" УБ. 1989, тал 64

<sup>29</sup> Мөн тэнд, тал 176

Миний залуугийн тоокууг мяндсан гүлдрүүтэй гэлдэнэ гэсэн богино магтаал дуу байдаг<sup>30</sup>. Мөн Зүүнгарын улс эвдэрч сарниж нүүхдээ дайснаас мөрөө бууруулж тоокуу оймс хийж өмссөн гэх домог бий<sup>31</sup>. Мөн торгуудын бас нэг өргөн дэлгэрсэн гутал нь булигааран түрийтэй, уланд нь эсгий ширж гадна талд нь үхрийн ширээр ширлэж хийсэн ятгар госон байжээ. Харин урианхайн настайчууд маага, залуучууд сөөкээ гэдэг гутал өмсөнө. Энэ гутлыг зөвхөн урианхайчууд хэрэглэнэ.

Эцэст дүгнэхэд, ойрадууд эдүгээ хүртэл түүхийн урт удаан хугацааны явцад монгол нутгийн баруун хэсгээр нутаглаж Монголын олон ястан, угсаатны бүлгээс ялгарах угсаа-соёлын өвөрмөц шинжийг бүрдүүлсэн байгаа нь ойрад хувцасны онцлогт хадгалагдан үлджээ гэж хэлж болно.

### Монгол-Ойрад хувцасны зарим нэр томъёоны нутгийн аялгууны харьцуулсан хүснэгт

№	Хувцас, хувцасны нэр томъёо (халх)	Дөрвөд	Захчин	Баяд	Өөлд	Урианхай	Торгууд
1	Малгай	malxā	- - - -	- - - -	- - - -	- - - -	maxlā
2	Залаа	dzalā	zalā	dzalā	zalā	dzalā	zalā
3	Сагалдарга	āāldārāā	saldarga	- - - -	- - - -	- - - -	- - - -
4	Шилэвч	gidžgīptšī	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
5	Дэглий	deglā	- - - -		- - - -	- - - -	- - - -
6	Оготор дээл	dekdēgēr dewēl	- - - -		- - - -	- - - -	- - - -
7	Хурган дээл	xursāgān dewēl	xursāxxān dewēl	Xursāgān	xursāxxān dewēl	xursāxxān dewēl	xursāxxān dewēl
8	Хөвөнтэй дээл	kōwāntā dewēl	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
9	Зувцаа	džulūbrūn dewēl	zulūwrūn dewēl	džulūbrūn dewēl	zulūwrūn dewēl	zulūwrūn dewēl	zulūwrūn dewēl
10	Цамц	kīlīg, kīlīg kīlīk	kīlīn	kīlīg, ēlīn	kīlīn	kīlīn	kīlīn
11	Тэрлэг	lawšāk	lawšāk, yawšak	lawšāk	lawšāk	lawšīg	lawšāk
12	Элгэн дээл	dzargāk dewēl	zargāk	dzargāk dewēl	zargāk	zargāk	zargāk
13	Элгэвч	elkēpši	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
14	Захны ухлаадас	M altāsān	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
15	Мөшгөөр	xoššā	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
16	Нударга	nudrūm, nuddūrūm	nuddūrūm	nudrūm	nudrūm	nuddūrūm	nudrūm
17	Ханцуй	xantsān	xants	xantsān	xantsān	xamtso	xantsān
18	Элбэг ханцуй	elwēk xantsān	elūg xants		elūg xantsān	elūg xamtso	elwēk xantsān
19	Хөвөө	kōwā	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -

<sup>30</sup> Арван гурван хүлгийн дуун. Эмхтгэсэн Ж.Цолоо УБ 1987, тал 5

<sup>31</sup> Х.Нямбуу "Хамгийн эрхэм ёсон" УБ. 1991, тал 11

20	Суга	sū	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
21	Шилбэ	šilīb	šilīw, šilūb	šilūw, šilīb	šilīb	šilū	šilū
22	Эмжээр	imdzār	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
23	Энгэр	öwūr	Öwār	öwūr	öūr	Öūr	Öwār
24	Бүс	Bis	- - - -	- - - -	- - - -	- - - -	- - - -
25	Өмд	Ümdn	Ümūd	ümdün	- - - -	- - - -	- - - -
26	Салтаа	algnak	alyāk	algnak	alyāk	alyāk	alyāk
27	Түдүүл	Öödāk	Öödüg	òödāk	Öödāk	òödüg	- - - -
28	Оймс	Ömsün	Ömsān	ömsün	ömsān	ömsān	Ömsān
30	Шагайвч	Šagābtšī	- - - -	- - - -	- - - -	- - - -	bašmāg
31	Зуузай	dzūzā	zūzā	dzūzā	zūzā	zūzā	zūzā
32	Зулаг	dzulāg	zulüg	dzulāg	zulüg	zulüg	zulüg
33	Тэвх(өсгий)	ösgā	öskā	Ösgā	öskā	öskā	Öskā
34	Хоншоор	xonšar	xönšör	xonšar	xönšör	xönšör	xönšör

## РЕЗЮМЕ

СВОЕОБРАЗИЕ ОЙРАТСКОЙ ОДЕЖДЫ И СРАВНИТЕЛЬНАЯ  
ХАРАКТЕРИСТИКА ТЕРМИНОВ МЕСТНЫХ ДИАЛЕКТОВ

В настоящей статье автор предпринял попытку выявить своеобразие одежды у ойрато-монголов начала XX века. Также на основе сравнительного анализа различных листовых диалектов автором создана схема некоторых терминов одежды ойратских этнических групп.